

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ - 307  
**ЗАХИАЛГАТ НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ**

- Энэ дүрэм ДБ-ийн сайдын 2002 оны 353 тоот тушаалаар батлагдаж, 2003 оны 02-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.
- Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд:  
1/ ЗТАЖ-ын сайдын 2007.05.04-ний өдрийн 77-р тушаалаар дүрмийн нэрийг өөрчилж, 307.2, 307.9-д өөрчлөлт оруулсан

<b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....</b>	<b>2</b>
307.1. Зорилго.....	2
307.2. Тодорхойлолт.....	2
307.3. Дүрмийн хамрах хүрээ.....	2
307.4. ИНЕГ-ын эрх.....	3
307.5. Төлбөр.....	3
307.6. Захиалгат нислэгийн ангилал.....	3
307.7. Нислэгийн захиалга .....	3
307.8. Тээвэрлэгч захиалгат нислэгийн хүсэлт гаргах.....	4
307.9. Захиалгат нислэгт хамаарах хязгаарлалт .....	4
307.10. Захиалгат нислэгийн гэрээ.....	4
<b>Б БҮЛЭГ. ТЭЭВЭРЛЭГЧ, ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ.....</b>	<b>5</b>
307.11. Тээвэрлэгчийн эрх, үүрэг .....	5
307.12. Захиалагчийн эрх, үүрэг .....	5
307.13. Тээвэрлэгчийн хариуцлага.....	6
<b>В БҮЛЭГ. ЗАХИАЛГАТ НИСЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА .....</b>	<b>6</b>
307.14. Про рейта захиалгат нислэгт тавигдах шаардлага .....	6
307.15. Захиалагч төлбөрийг нь хариуцах захиалгат нислэгт тавигдах шаардлага.....	7
307.16. Холимог төлбөрт захиалгат нислэгт тавигдах шаардлага ..	7
307.17. Нэмэлт мэдээлэл.....	7
<b>Г БҮЛЭГ. ЗАХИАЛГАТ НИСЛЭГИЙН ЗОХИЦУУЛАЛТ .....</b>	<b>7</b>
307.18. Үйл ажиллагааны нөхцөл .....	7
307.19. Захиалгат нислэгийн зохицуулалт .....	7
<b>ХАВСРАЛТ А-1.....</b>	<b>8</b>
<b>ХАВСРАЛТ А-2.....</b>	<b>10</b>
<b>ХАВСРАЛТ Б. ....</b>	<b>13</b>

## ЗАХИАЛГАТ НИСЛЭГИЙН ЗӨВШӨӨРӨЛ

### А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### **307.1. Зорилго**

Энэ дүрмээр Агаарын тээвэрлэгч /цаашид Тээвэрлэгч гэх/-ийн үйлдэх захиалгат нислэгийн тээвэрлэлтийн зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

#### **(R) 307.2. Тодорхойлолт**

*Агаарын тээвэрлэгч* гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн аж ахуйн нэгж, байгууллагыг;

*Жуулчны агент* гэж захиалгат нислэгт зориулан бүлэг зорчигчдыг бүрдүүлэх болон тээвэрлэлтийг борлуулахад оролцож буй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагыг;

*Захиалагч* гэж Тээвэрлэгчид нислэг захиалж буй этгээдийг;

*Захиалгат нислэг* гэж захиалгын гэрээгээр зохицуулагдаж байгаа хуваарьт бус, нэмэлт бус нислэгийг;

*Захиалагч төлбөрийг нь хариуцах нислэг* гэж нислэгийн төлбөрийг тухайн нислэгийг захиалагч хариуцах нислэгийг;

Агаарын тээврийн үйл ажиллагааны *зөвшөөрөл* гэж хуваарилсан нислэгийн шугаманд үзүүлэх агаарын тээврийн үйлчилгээний төрөл, нөхцөлийг тодорхойлсон, үйл ажиллагаа явуулах эрхийг олгож буй баримт бичгийг;

*Про рейта (Pro rata) захиалгат нислэг* гэж нислэгийн төлбөрийг тээвэрлэсэн зорчигч тутамд хуваан ногдуулдаг нислэгийг;

*Холимог төлбөрт захиалгат нислэг* гэж нислэгийн төлбөрийг захиалагч болон захиалагчид хамаарахгүй бусад зорчигчдод хэсэгчлэн хариуцуулдаг нислэгийг тус тус хэлнэ.

#### **307.3. Дүрмийн хамрах хүрээ**

Энэ дүрэм нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээрээс нислэгийн цэг нь эхлэх олон улсын болон орон нутгийн захиалгат нислэгт хамаарна.

#### **307.4. ИНЕГ-ын эрх**

Энэ дүрмийн дагуу гүйцэтгэх захиалгат нислэгийн зөвшөөрөл олгохтой холбогдсон бүрэн эрх ИНЕГ-т хадгалагдана.

#### **307.5. Төлбөр**

(а) Захиалгат нислэгийн нийт зардлаас Тээвэрлэгчид төлсөн, эсхүл төлөхөөр тохиролцсон хөлсийг тухайн нислэгийн төлбөр гэж үзнэ.

---

(б) Захиалгат нислэгийн төлбөрийг энэ дүрмийн 307.6-д заасан ангиллаас хамааран Захиалагч болон Жуулчны агент, эсхүл зорчигч хариуцна.

(в) Захиалгат нислэгийн гэрээнд дурьдсаны дагуу Тээвэрлэгчийн дансанд шилжүүлсэн төлбөрийг Тээвэрлэгчид төлсөн захиалгат нислэгийн төлбөр гэж тооцно.

### **307.6. Захиалгат нислэгийн ангилал**

Захиалгат нислэгийг, төлбөрийн хуваарилалтаас нь хамааран дараах байдлаар ангилна:

- 1/ Захиалагч төлбөрийг нь хариуцах захиалгат нислэг;
- 2/ Про рейта (Pro rata) захиалгат нислэг;
- 3/ Холимог төлбөрт захиалгат нислэг.

### **307.7. Нислэгийн захиалга**

(а) Захиалагч нь, нислэг эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Тээвэрлэгчид захиалгаа ирүүлнэ.

(б) Энэ зүйлийн (а)-д дурьдсан захиалгад дараах мэдээллийг хавсаргасан байна :

- 1/ төлөвлөсөн нислэгийн огноо;
- 2/ чиглэл;
- 3/ ашиглах суудлын тоо;
- 4/ нэг талын, эсхүл явах/ирэх нислэг;
- 5/ захиалгат нислэгийн төлбөрийн ангилал;

6/ тухайн Тээвэрлэгчээр хуанлийн 1 жилийн хугацаанд хэдэн удаагийн захиалгат нислэг гүйцэтгүүлсэн болон гүйцэтгүүлэх тухай.

(в) Захиалагч нь энэ зүйлийн (б)-д зааснаас гадна, Хавсралт А-1, Хавсралт А-2-т заасан нэмэлт мэдээллийг бүрдүүлнэ.

(г) Энэ дүрмийн 307.8-ын (а)-д зааснаас бусад тохиолдолд Тээвэрлэгч нь нислэгийн захиалгыг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэнэ.

### **307.8. Тээвэрлэгч захиалгат нислэгийн хүсэлт гаргах**

(а) Тээвэрлэгч нь дараах тохиолдолд захиалгат нислэг үйлдэх тухай хүсэлт гаргана:

- 1/ олон улсын захиалгат нислэг гүйцэтгэх;
- 2/ өөр Тээвэрлэгчийн тогтмол нислэг гүйцэтгэдэг чиглэлд захиалгат нислэг гүйцэтгэх;
- 3/ тухайн Тээвэрлэгчийн хувьд зөвшөөрөгдсөн чиглэлээс өөр чиглэлд захиалгат нислэг гүйцэтгэх;

4/ Энэ дүрмийн Г бүлэгт заасны дагуу захиалгат нислэг гүйцэтгэх.

(б) Тээвэрлэгч нь захиалгат нислэгийн тухай хүсэлтээ тухайн нислэгийг гүйцэтгэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-т ирүүлнэ.

(в) ИНЕГ нь захиалгат нислэгийн тухай хүсэлтийг ажлын 5 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.

---

**(R) 307.9. Захиалгат нислэгт хамаарах хязгаарлалт**

(а) Тээвэрлэгч нь, ИНЕГ-аас захиалгат нислэгийн тухай хүсэлтийг шийдвэрлэх хугацаанд захиалгат нислэг гүйцэтгэхийг хориглоно.

(б) Захиалагч нь гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд захиалгат нислэгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлахгүй.

**307.10. Захиалгат нислэгийн гэрээ**

(а) Захиалгат нислэгийн гэрээг бичгээр үйлдэх ба Тээвэрлэгч болон захиалагчийн эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

(б) Захиалгат нислэгийн гэрээнд дараах нөхцлүүдийг тусгана:

1/ Гэрээ байгуулсан огноо, байгуулсан газар;

2/ Гарын үсэг зурсан талуудын нэр, албан тушаал, гарын үсэг ;

3/ Нислэг үйлдэх он, сар, өдөр, нислэгийн чиглэл;

4/ Агаарын хөлгийн маяг, шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийн багтаамж:

(i) зорчигчийн боломжит суудлын тоо;

(ii) ачаа тээвэрлэх боломжит даац;

5/ Захиалгат нислэгийн төлбөрийн ангилал, нийт төлбөр, нислэгийн болон бусад төлбөр, захиалгат нислэгт хэрэглэх тариф, төлбөрийн хэлбэр;

6/ Захиалгат нислэгийн урьдчилсан төлбөрийн хэмжээ, төлбөр хийх, эсхүл төлбөрийн баталгаа гаргасан этгээдийн нэр, хаяг;

7/ Төлбөрийг буцаах болон торгууль ногдуулах нөхцөл;

**Б БҮЛЭГ. ТЭЭВЭРЛЭГЧ, ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**307.11. Тээвэрлэгчийн эрх, үүрэг**

(а) Захиалгат нислэг гүйцэтгэх Тээвэрлэгч нь дараах эрхтэй:

1/ захиалгат нислэг үйлдэх агаарын хөлгийн маягийг тогтоох;

2/ орон нутгийн Захиалгат нислэг гүйцэтгэх тохиолдолд нислэгийн төлбөрийг нислэг эхлэхээс 5 хоногийн өмнө Захиалагчаас нэхэмжлэх;

3/ олон улсын захиалгат нислэг гүйцэтгэх тохиолдолд тухайн нислэгийн төлбөрийг, эсхүл төлбөрийн талаарх баталгааг нислэг эхлэхээс 10-аас доошгүй хоногийн өмнө Захиалагчаас нэхэмжлэх.

(б) Захиалгат нислэг гүйцэтгэх Тээвэрлэгч нь дараах үүрэгтэй:

1/ захиалгат нислэгийг аюулгүй гүйцэтгэх;

2/ захиалгат нислэгийн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх;

3/ захиалгат нислэгийн зорчигчдын нэрсийн жагсаалтыг ИНД-331-ийн шаардлагын дагуу бүрдүүлэх.

**307.12. Захиалагчийн эрх, үүрэг**

(а) Захиалагч дараах эрхтэй:

---

1/ Захиалгат нислэгийг гэрээнд заасан хугацаанд, аюулгүй гүйцэтгэхийг Тээвэрлэгчээс шаардах;

2/ Тээвэрлэгч захиалгат нислэгийг цуцалсан тохиолдолд Тээвэрлэгчээс нислэгийн төлбөр болон хохирлоо нэхэмжлэх.

(б) Захиалагч дараах үүрэгтэй:

1/ захиалгат нислэгийн зорчигчдын нэрсийн жагсаалтыг нислэгийн чиглэл тус бүрээр гаргаж Тээвэрлэгчид өгөх;

2/ захиалгат нислэгт хамаарах мэдээллийг Хавсралт А-1, А-2-ын дагуу гаргаж Тээвэрлэгчид өгөх;

3/ олон улсын захиалгат нислэгийн зорчигч, ачааг тухайн улсад нэвтрэх, дамжин өнгөрөхөд шаардагдах бүрдүүлэлт (хил, гааль, хорио цээрийн)-ийг хариуцах.

### **307.13. Тээвэрлэгчийн хариуцлага**

Тээвэрлэгч нь урьдчилсан төлбөр хийгдсэн захиалгат нислэгийг гүйцэтгэх боломжгүй бол захиалгат нислэгийг цуцалснаас хойш 5 хоногийн дотор Захиалагчид төлбөрийг буцааж олгосон тохиолдолд тухайн захиалгат нислэгт хамаарах хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## **В БҮЛЭГ. ЗАХИАЛГАТ НИСЛЭГТ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **307.14. Про рейта захиалгат нислэгт тавигдах шаардлага**

(а) Про рейта захиалгат нислэгийн зорчигчдыг Жуулчны агент болон Захиалагч бүрдүүлнэ.

(б) Захиалагч нь, зорчигчид ногдох тариф зорчигчдын тооноос хамааран нэмэгдэх буюу буурч болохыг зорчигчдод мэдэгдсэн байна.

(в) Захиалгат нислэгийн төлбөрийг тухайн нислэгийн дор дурьдсанаас бусад бүх зорчигчдод адил тэнцүү хувааж ногдуулна:

1/ 12 буюу түүнээс доош насны хүүхдийг зорчигчийн тарифаас бага тарифаар тээвэрлэнэ,

2/ 2 буюу түүнээс доош насны хүүхдүүдийг төлбөргүй тээвэрлэж болно.

(г) Захиалагч нь, нислэгийг зохион байгуулахтай холбогдсон бодит үнэлгээнээс давсан зардлыг захиалгат нислэгийн зорчигчдоор төлүүлэхгүй.

(д) Захиалгат нислэгийг зохион байгуулахтай холбогдсон зардлыг захиалгат нислэгийн зорчигчдод адил тэнцүү хуваахад үндсэн захиалгат нислэгийн төлбөрөөс илүү гарсан тохиолдолд илүү төлбөрийг захиалгат нислэгийн зорчигчдод тэнцүү хувааж буцаан олгоно.

---

### **307.15. Захиалагч төлбөрийг нь хариуцах захиалгат нислэгт тавигдах шаардлага**

(а) Захиалагч төлбөрийг нь хариуцах захиалгат нислэгийн зорчигчдыг Захиалагч бүрдүүлнэ.

(б) Захиалагч нь захиалгат нислэгийн гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл тухайн нислэгийн талаар нийтэд зарлахгүй.

### **307.16. Холимог төлбөрт захиалгат нислэгт тавигдах шаардлага**

(а) Холимог төлбөрт захиалгат нислэгийн зорчигчдыг Жуулчны агент болон Захиалагч бүрдүүлнэ.

(б) Захиалгат нислэгийн гэрээнд зорчигчдыг бүрдүүлэх нөхцөлийн талаар тусгасан тохиолдолд Тээвэрлэгч холимог төлбөрт захиалгат нислэгийн зорчигчдыг бүрдүүлэхэд оролцож болно.

### **307.17. Нэмэлт мэдээлэл**

Захиалагч нь энэ дүрмийн 307.14-ийн шаардлагын дагуу Хавсралт А-2-т заасан, энэ дүрмийн 307.15, 307.16-гийн шаардлагын дагуу Хавсралт А-1-д заасан нэмэлт мэдээллийг бүрдүүлнэ.

## **Г БҮЛЭГ. ЗАХИАЛГАТ НИСЛЭГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **307.18. Үйл ажиллагааны нөхцөл**

Энэ бүлгийн дагуу зөвшөөрөгдсөн захиалгат нислэгийг гүйцэтгэхийн өмнө Тээвэрлэгч нь:

1/ нислэгтэй холбогдох зохицуулалтыг хийсэн байна;

2/ аэродромын бэлэн байдал, газрын үйлчилгээний хангалтын талаар холбогдох арга хэмжээг авсан байна.

### **307.19. Захиалгат нислэгийн зохицуулалт**

(а) Захиалгат нислэгийн гэрээнд тухайн захиалгат нислэгт ашиглах түр аэродром, газрын үйлчилгээний бүх нөхцлийг тусгасан байна.

(б) Тээвэрлэгч болон Захиалагч нь түр аэродром ашиглах, газрын үйлчилгээ шаардагдах чиглэлд захиалгат нислэг гүйцэтгэхдээ ИНЕГ-аас тавигдах шаардлагыг дагаж мөрдөнө.

---

## ХАВСРАЛТ А-1

Захиалагчийн бүрдүүлэх мэдээлэл.

1. Тээвэрлэгчийн нэр;
2. Төлөвлөж буй нислэг эхлэх хугацаа;

(а) Явах

(б) Буцах

3. Төлөвлөсөн нислэгийн маршрут:

(Тайлбар: Ижил чиглэлд, нэгээс дээш нислэг захиалсан тохиолдолд давтамжийг бичнэ, өөр өөр чиглэлд захиалсан тохиолдолд нислэг тус бүрт мэдээлэл бүрдүүлнэ.)

(а) Явах \_\_\_\_\_ аас \_\_\_\_\_ хүртэл

(б) Буцах \_\_\_\_\_ аас \_\_\_\_\_ хүртэл

(в) Завсрын буулт хийх нисэх буудал, нислэгийн бусад цэг :

4. Агаарын хөлөг:

(а) Ашиглах агаарын хөлгийн төрөл:

(б) Суудлын багтаамж:

(в) Тээвэрлэх зорчигчдын тоо:

5. Захиалгат нислэгийн нийт төлбөр:

6. Нэмэлт үйлчилгээ :

(а) Тээвэрлэгч нь тээвэрлэлтэд нэмэлт үйлчилгээ үзүүлэх эсэх:

Тийм [ ] Үгүй [ ]

(б) Нэмэлт үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлэх этгээд, бусад мэдээлэл:

7. Захиалагчийн нэр, хаяг

8. Нислэгийн зорилго

9. Захиалгат нислэгийн гэрээ байгуулсан огноо

10. Тарифыг Жуулчны агентад мэдэгдсэн эсэх :

Тийм [ ] Үгүй [ ]

Мэдээллийг бүрдүүлсэн:

/албан тушаал, гарын үсэг/

---

## ХАВСРАЛТ А-2

Про рейта нислэгийн захиалагчийн бүрдүүлэх мэдээлэл

1. Захиалагчийн нэр, хаяг
2. Захиалагчийн эрхэлдэг үйл ажиллагаа
3. Үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа
4. Захиалгат нислэгийн талаар ямар нэг тайлбар байгаа эсэх

Тийм [ ] Үгүй [ ]

5. зорчигчдын бүтэн нэр, хаяг, утасны дугаарыг багтаасан нэрсийн жагсаалт

*Тайлбар: Нислэг эхлэхээс өмнө зорчигч нэмэгдэх болон хасагдсан тохиолдолд нэрсийн жагсаалтад тухай бүр өөрчлөлт оруулна.*

6. Захиалгат нислэгт оролцогчдод тавигдаж буй шаардлага:
- 

7. Захиалгат нислэгийн зорчигчдыг хэн бүрдүүлсэн /холбогдох баримтыг хавсаргана/:
- 

8. Захиалгат нислэгийн зорчигчдын тоо ....., үүнээс:

i/ Захиалагчийн бүрдүүлсэн зорчигчид

ii/ Жуулчны агентын бүрдүүлсэн бүлэг зорчигчид

iii/ бусад

9. Хэрэв захиалгат нислэгт жуулчны агентаас бусад зуучлагч оролцож байгаа бол тэдгээрийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл:
- 

10. Тооцоолсон тариф (нэг зорчигчид ногдох): \_\_\_\_\_ (төгрөгөөр, эсхүл ам.доллар) х (зорчигчдын тоо) \_\_\_\_\_ = \_\_\_\_\_ (Захиалгат нислэгийн тооцоот үнэлгээ)

11. Бусад нэмэлт төлбөр байгаа эсэх:

Тайлбарлах:

- (а) Нийт хүлээн авах төлбөр: \_\_\_\_\_

Тооцоот зардал, агаарын хөлгийн захиалгыг оролцуулан:

Төлөгдөх хэмжээ:

- (б) Нийт зардал: \_\_\_\_\_

*/ (а) болон (б)-гийн хооронд ялгаа байгаа бол тайлбарла/*

12. Нислэгийг захиалагчид төлөх, 10-р зүйлд оруулсан зардлууд байгаа эсэх:

Тийм [ ] Үгүй [ ]

Хэрэв тийм бол хэмжээ, ямар үйлчилгээний төлбөр болохыг тайлбарлах.

13. Хөнгөлөлттэй болон төлбөргүй тээвэрлэх зорчигч байгаа эсэх:

---

Тийм [ ] Үгүй [ ]

(а) 2 хүртэлх насны хүүхэд

(б) бусад

14. Захиалгат нислэгийн төлбөрийг тээвэрлэх зорчигч тутамд адил тэнцүү хуваах эсэх:

Тийм [ ] Үгүй [ ]

15. Нислэгийн нэг талын зорчигчдын тоо болон явах/ирэх нислэгийн чиглэл тус бүрд тусгаарлан заах:

(а) явах : ... (б) ирэх : ... (в) нийт: ...

16. Бүлэг зорчигчид нь явах/ирэх чиглэлд явах эсэх:

Тийм [ ] Үгүй [ ]

Тайлбарлах:

17. Захиалагч нь ИНЕГ-ын холбогдох дүрмүүдтэй танилцсан эсэх:

Тийм [ ] Үгүй [ ]

18. Хавсаргасан бичиг баримт, хуудасны тоо:

Мэдээллийг бүрдүүлсэн:

/албан тушаал, гарын үсэг/

---

## ХАВСРАЛТ Б.

*Жуулчны агент бүрдүүлж Тээвэрлэгч болон Захиалагчид хүргүүлнэ.*

1. Жуулчны агентаас Захиалагчид үзүүлэх үйлчилгээ
2. Жуулчны агентаас захиалгат нислэгийн зорчигчдод үзүүлэх үйлчилгээ
3. Жуулчны агент нь захиалгат нислэг болон газраар тээвэрлэхтэй холбоотойгоор зорчигчдоос төлбөр авсан эсэх

Тийм [ ] Үгүй [ ]

Хэрэв тийм бол Тээвэрлэгчид хамаарах төлбөрийн талаар тайлбарлах

4. Жуулчны агент нь жуулчин зорчигчийн тээвэрлэлтэд холбогдох бичиг баримт (виз, зөвшөөрөл болон бусад)-ыг бүрдүүлсэн эсэх

Тийм [ ] Үгүй [ ]

Тайлбар:

5. Зорчигчдын нэрсийн жагсаалтыг хавсаргана.

Мэдээллийг бүрдүүлсэн:

/албан тушаал, гарын үсэг/

\* \* \*